



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-10</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>11-19</i>
<hr/>	
<i>1. Хууль тогтоолын төслийг эцэслэн батлах</i>	<i>11-19</i>
<i>2. Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>19-19</i>

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 09-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 16 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аюурсайхан, Д.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Ж.Чинбүрэн, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболо, Б.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Батсуурь, Д.Сарангэрэл, Ч.Ундрам;

Тасалсан: С.Батболд, Б.Баярсайхан, Ж.Мөнхбат, Ц.Мөнхцэцэг, Ц.Сэргэлэн, Ж.Эрдэнэбат;

Хоцорсон: Ш.Адъяаа-10 минут, С.Амарсайхан-29 минут, Ж.Бат-Эрдэнэ-12 минут, Д.Ганбат-30 минут, Н.Ганибал-21 минут, Т.Доржханд-22 минут, Б.Жавхлан-28 минут, Л.Мөнхбаатар-42 минут, Ц.Мөнх-Оргил-33 минут, Х.Нямбаатар-37 минут, С.Одонтуяа-34 минут, Д.Цогтбаатар-20 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

Нэг.Хууль, тогтоолын төслийг эцэслэн батлах /Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 8

Бүгд: 50

84.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 9

Бүгд: 52

82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Аялал, жуулчлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 14

Бүгд: 52

73.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар техникийн саатлын улмаас зарим гишүүдийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 12

Бүгд: 53

77.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 12

Бүгд: 53

77.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 9
Бүгд: 53

83.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 9
Бүгд: 53

83.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 11
Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 11
Бүгд: 54

79.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Концессын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 12
Бүгд: 54

77.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 11
Бүгд: 54

79.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 14

Бүгд: 54

74.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 10

Бүгд: 54

81.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 12

Бүгд: 54

77.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 10

Бүгд: 54

81.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 13

Бүгд: 53

75.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 10

Бүгд: 55

81.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 10
Бүгд: 55

81.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 11
Бүгд: 56

80.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 13
Бүгд: 56

76.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

21.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 12
Бүгд: 56

78.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

22.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 15
Бүгд: 56

73.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

23.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 13
Бүгд: 56

76.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

24.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 13
Бүгд: 56

76.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

25.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 12
Бүгд: 56

78.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

26.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 10
Бүгд: 56

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

27.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 10
Бүгд: 56

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

28.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 11
Бүгд: 56

80.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

29.Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 12
Бүгд: 55

78.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

30.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 10

Бүгд: 55

81.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

31.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 13

Бүгд: 55

76.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

32.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 7

Бүгд: 55

87.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

33.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 9

Бүгд: 55

83.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан:

34.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 12

Бүгд: 55

78.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Г.Занданшатар: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 6

Бүгд: 55

89.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Г.Занданшатар: Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 12
Бүгд: 54
77.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулж дууслаа.

Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 32 тоот албан бичгээр “Дарханы арьс ширний цогцолборын үйл ажиллагааны талаар” тавьсан асуулгын хариуг хэлэлцэхийг хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулж, хуралдааны тов, дарааллаас хойшлуулж байгаа тухай мэдэгдэв.

Хоёр. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Г.Занданшатар: “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 19
Бүгд: 55
65.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:10/

Уг асуудлыг 11 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 55 минут үргэлжилж, 76 гишүүнээс 56 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 11 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ
2022 оны 12 дугаар сарын 09-ний
өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 16 минут
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгаж мэндчилье.

Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 09-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Нийт 36 төсөл байна.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Хот,суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хоёр.Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал. Ийм асуудал байна.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Дарханы арьс ширний цогцолборын үйл ажиллагааны талаар” тавьсан асуулгын хариуг сонсохоор байгаа.

2022 оны 12 сарын 08-ны өдөр Засгийн газраас асуулгын тухай бичиг ирүүлсэн байна. Дараа танилцуулна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад үг хэлэхээр санал ирсэн байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягаас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу 12 дугаар сарын 09-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэн тул зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг гэсэн ийм бичиг ирүүлсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг хэлэлцэх асуудалтай холбогдуулж, тов, дараалал өөрчлөх, асуудал нэмэх талаар горимын санал гаргаж үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Сая тэндээс хэн хэлэв нэг нь хэлж байна. Юун Дарханы арьс ширний үйлдвэр вэ гэж. Нээрээ юун Дарханы арьс ширний үйлдвэр вэ. Хэдүүлээ энэ ард иргэдээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд байна даа жаахан сэрж, сэдэж жаахан юм хийхгүй юм уу. Гадаа үнийн өсөлт, ахуйн амьжиргааны доройтлоос болоод иргэд бухимдаж, жагсаж, цуглаж, залуучууд өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж байна. Бид нар энд дүлийн дүмбэ царайлаад, хэдэн малын арьсаа тэгнэ, ингэнэ гээд ярих ёстой л доо, гэхдээ өнөөдөр ярих асуудал мөн үү, биш үү.

Ер нь энэ Улсын Их Хурлын дайчин, давшингуй, шуурхай байдал жаахан дутагдаад байна уу гэж би бодож өнөөдөр үг хэлье гэсэн юм. Баялагтаа эзэн болъё гэж хэдэн жил ярьцаав. Одоо тэгээд баялгийг чинь хулгайлаад дууслаа. Нүүрс хулгайлагдаад дуусааж байна. Одоо алт бас зэс хулгайлагдаж байгаа шүү дээ. Тэгээд тэр зэстэй холбоотой хулгайг зогсооё гээд тогтоолын төсөл оруулсан явж байгаа. Энэ Алтанхуягийн асуудал юм уу, энэ Ардчилсан намын асуудал биш юм. Энд парламентын танхимд хэдэн хүн үг хэлээд байгаа юм. Одоо манай олонх жаахан анхаараач. Яах вэ дээ олонх хэтэрхий олон болчихоор жаахан

бяр суучхаад буруутаад байх шиг байна даа.

Өнөөдрийн Засгийн газрын явуулж байгаа энэ нүүрсний хулгайтай тэмцэнэ гэж байгаа. Хэрвээ үнэн бол дэмжмээр байна. Би сүүлийн үед үнэн ярьж байна уу, худлаа ярьж байна уу гэдгийг жаахан эргэлздэг болсон. Ард түмэн ингэж эргэлздэг болсон учраас хэчнээн олон юмтай тэмцэв ээ. Тэгээд шийдэл нь юу болов. Үнэхээр энэ нүүрсний хулгайтай тэмцэнэ, тэгээд ямар хулгай байна, зэсийн хулгайтай тэмцэнэ гэж байгаа бол би шууд дэмжмээр байна. Гэхдээ ямар нэгэн хулгайч нартай тэмцэхдээ ямар нэгэн буруу зүйлтэй тэмцэхдээ энд сууж байгаа хэдэн гишүүдийн нэрийг ээлжилж хэлчхээд ингээд ажил чинь нураад байгаа шүү дээ. Яг чулуу шидэхэд жаран хэдэн хүнээс олон хүний толгой хагарах ёстой л доо энэ нүүрс дээр. Тийм учраас ажил хийхгүй байна. Тэгээд би нэг юм хэлье. Парламентын ардчиллыг хамгаалъя Ардын намын гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүд ээ. Энэ яаж байна вэ гэхээр энд үг хэлүүлэхгүй байна. Үг хэлэхээр тэр хүнийг барьж иднэ. Энэ 10-аадхан хүнийг. 10-аад хүнээ барьж идээд байхаар чинь та нарын энэ болж байгаа, болохгүй байгаа юмыг чинь хэлэх хүн олдохоо больсон энэ 10 дотор. Муу Пүүжээ л өчигдөржингөө орилно лээ. Энийгээ ярихгүй юм уу та нар.

Тэр хяналтын ажлын хэсгийн цөөнхөөр толгойлуулчихвал яасан юм. Тэртээ тэргүй тэр ажлын хэсэгт нөгөө 60 хэд чинь олонх л байгаа шүү дээ. Юунаас айгаад байгаа юм. Яагаад юмыг шударга хийж чадахгүй байгаа юм бэ та нар. Яагаад аалзны тор шиг хоорондоо сүлжилдээд, нэг нэгнийгээ нэг нэг юмаар барьцаалчхаад ингээд байгаад байгаа юм бэ.

Алт, зэс, нүүрс, хүдэр. Энийгээ жаахан янзалж болохгүй юм уу. Би та нарт конструктивный санал хэлэх гэсэн юм. Хэдүүлээ энэ нойрноосоо сэрээд жаахан ажил хийе л дээ. Би тэр

нүүрсний хулгайн ажлын хэсэгт орё гэсэн өмнө нь нүүрсний хулгай гэж бичээгүй байсан л даа. Боомт хавийн юм гээд. Яагаад цөөнхийн нэг гишүүн энэ ажлын хэсэгт ороод ажиллаж болдоггүй юм. Ороод ирэхээр та нар их сонин хууль баталчхаж. Ажлын хэсэгт Их Хурлын гишүүн орох эсэхийг кнопоор шийднэ гээд намайг унагаачих юм. Болиоч дээ. Эсвэл зарим нь та нар анзаараагүй байх.

Занданшатар дарга аа, юу яая. Одоо манай хууль дээр ингэж байгаа шүү дээ. Их Хурлын гишүүн ажлын хэсэгт орно өөрийнх нь эрх, гарна өөрийнх нь эрх. Тэрийг яах гэж Их Хурал дээр оруулж ирж 60 хэдэн хүн кноп дарж унагааж байгаа юм. Энэ нөхөр оруул гэлээ, хяналт шалгалтад энийг оруулна, энийг оруулахгүй гэж яагаад ингэж шийддэг юм. Болохгүй шүү дээ. Хэдүүлээ оруулаад хийгээд явчихъя. Парламентын ардчиллаа бэхжүүлъя. Цөөнхөөрөө янз бүрийн юмнуудаа хийлгэ ээ. Та нар битгий айгаад бай. Арьс, ширээ түр хойшлуулчих аа. Өнөөдрийн хурлын үйл ажиллагааг жаахан өөр явуулмаар байна. Тэгээд юм яримар байна. Нүүрсний хулгай гээд. Хүмүүс хараад уурлана биз дээ. Хэдэн өдөр энэ залуучууд янз бүрийн санал хэлээд, улс орноо өөд нь татъя, хулгайгаа зогсооё гэхээр тэгье тэгье, гэхдээ бид нар ажиллаж байна, та нар тайван амгалан бай. Энийг больё л доо. Энийг та нарт уриалж байна, би гуйж байна, хүсэж байна. Энэ чинь тогтоом биш ээ. Энэ байдал чинь олон хоног үргэлжилбэл улс орны хувь заяанд хүрнэ. Энэ танай намын хувь заяа биш ээ. Монгол Улсын хувь заяа шүү. Анхаараад өг л дөө, ажил хий л дээ.

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудалтай холбогдуулж Норовын Алтанхуяг гишүүн үг хэллээ.

Эрхэм гишүүд ээ, өнөөдөр олон улсын авлигатай тэмцэх өдөр тохиож байна. Ер нь энэ шударга ёс, хууль засагласан, хөгжсөн эдийн засагтай шинэ ирээдүйг цогцлооход хамгийн том

саад учруулж байгаа үзэгдэл бол авлигал гэдгийг бүгд мэддэг, ярьдаг. Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг төсвийн томоохон хэсгийг бүрдүүлж байгаа Эрдэнэт, Хөгжлийн банк, Эрдэнэс тавантолгой гээд төрийн өмчит компаниудыг тойрсон авлигал, албан тушаалын болон нүүрсний хулгай гэдэг энэ тодотголтой гэмт хэргүүд шалгагдаж байна. Албан тушаалтнуудын оролцоотой авлигын томоохон гэмт хэргүүд иргэд, олон нийтийг ихэд бухимдуулж, төрд итгэх итгэлийг алдагдуулж байна.

Авлига улс орны аюулгүй байдалд заналхийлж байна. Ардчилсан тогтолцоо, үнэт зүйлсийг дордуулж байна. Хөгжлийг сааруулж, төрд итгэх итгэлийг алдагдуулж байна. Авлигын өр төлбөрийг ард түмэн ирээдүйгээрээ, улс орон хөгжил дэвшлийн боломжоороо төлдөг учраас залуучууд, ард иргэд бухимдаж, жагсаж, цуглаж, үзэл бодлоо илэрхийлж байна.

Засаглалаа тэр дотроо парламентын ардчиллаа бэхжүүлж, чадавхжуулж чадаагүй цагт бид ямар ч сайн бодлого дэвшүүлээд нэмэргүй байна. Засаглалыг сайжруулахын тулд төрийн албаны бүх шатанд авлигал, хүнд суртлыг таслан зогсоох ёстой. Ийм учраас өнөөдөр ажлын хэсгүүд хуралдаж, гишүүд тойргийнхоо сонгогчдын санал бодлыг сонсож, авлигатай тэмцэх өдөр авлигатай тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох 3 багц хуулийг яаралтай хэлэлцэх бэлтгэлийг өнөөдөр хангаж, ирэх 7 хоногоос хэлэлцүүлэгт оруулах хэрэгтэй байна. Энэ дотор нэгдүгээрт,

Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт. Ирээдүй хойч үеийн боломжийг хулгайлж байгаа, үгүй хийж байгаа авлигал хээл хахуулийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд авлигачдад хуулийн хатуу хариуцлага тооцохгүйгээр энэ зорилгод олигтой ахиц гарахгүй. Залуучуудын тавьж байгаа

шаардлага Эрүүгийн хуулийн 22.1-ийг яриад байна. Эрүүгийн хуулийн 22.1 тэр хөрөнгө хураах, ялын бодлогыг чангатгах, Эрүүгийн хуулийн авлигатай тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах ийм өөрчлөлтийг хийе.

Хууль бол хулгай хийхгүй байгаа шүү. Хуулийг хэрэгжүүлэхдээ хулгай хийж байгаа. Үнэхээр хууль хэрэгжүүлэхэд, хуульд алдаа байгаа бол тэрийг оруулаад ир гэж байгаа шүү дээ. Энийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газар, Хууль зүйн байнгын хороо оруулаад ир, өнөөдөр ажиллацгаа.

Ингээд Эрүүгийн хууль дахь авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой ялын бодлогыг чангаруулах, авлигын гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх. Тэр 22.1. Яригдаад байгаа хөрөнгө хураах ял бий болгох, энэ өөрчлөлтүүдийг нэн тэргүүнд хийе. Ял наймаацдагаас авхуулаад асуудлуудыг яриад байна.

Хоёрдугаарт, энэ байгалийн баялгийг ийм баян орон мөртөө ард иргэд нь ядуу амьдраад байна, энийг хулгайлаад байна гэдэг ард нийтийн маш том үзэл хандлага байна. Энэ бодитой үнэн. Энэ орлого, авлигын ялгааны нэг үндэс суурь мөн. Ийм учраас олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг баталж гаргах хэрэгтэй байна. Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бүх этгээдийн олборлох үйлдвэртэй холбогдох мэдээллийн олон нийтэд ил тод болгоё. Ард түмний хяналт гэдэг бол албан тушаалын хяналтаас илүү хүчтэй. Ингэснээр ард түмний баялаг эдийн засгийг хангагч өсөлтийг хангаж байгаа өнөөдрийн валютын ханиш, эрсдэлийг сэргийлэх гол нөхцөл болж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиа нээлттэй ил тод байдлаар худалдаалдаг энэ хуулиа батлан гаргая. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай ажлын хэсэг өнөөдөр хуралдаад, эцэслээд ирэх 7 хоногт эцэслэн батлахаар явна.

Баялагийг хулгайн замаар зарж байгаа нүүрсний хулгай, нүүрсний мафийг таслан зогсоож, ил тод үнээр гэрээ хийх нөхцөлийг бүрдүүлье.

Гуравдугаарт, Улсын Их Хурлаар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэлэлцэж байна. Авлигатай тэмцэх үр дүнтэй аргын нэг бол нийтийн сайн сайхны төлөө нийгэмд бугисан хээл хахууль авлигал, хууль бус үйлдлийг илчлэн мэдээлэгчийг хамгаалж, иргэдийн оролцоонд түшиглэх явдал. Энэ үедээ бас нэг зарчим баримтлах хэрэгтэй байна. Ялаагаа, жоомоо алах гээд гэрээ шатааж болохгүй. Хулгайтай бид тэмцэх ёстой. Гэхдээ хулгайтай тэмцэх гэж байгаа гээд ардчиллаа, парламентын ардчиллаа доройтуулж, мөхөөж болохгүй. Өнөөдрийн геополитикийн нөхцөл, гадаад дотоод нөхцөл байдал хүнд байгаа үед үндэсний эв нэгдлээ сахин хамгаалж, парламентын ардчиллаа хамгаалах ёстой. Энийг парламентын гишүүд бид тууштай хамгаалах ёстой. Үүний тулд шударга бус зүйлтэй тэмцэх ажлыг эв нэгдэлтэй тэмцэх ёстой. Үүний тулд би Алтанхуяг гишүүний цөөнхийнхөө үгийг сонсьё, цөөнхөөрөө тэр сонгуулийн тогтолцоо, энэ авлигатай тэмцэх асуудлын хяналтыг тавиулъя гэдэг санал бол зүйтэй. Хяналт, шалгалтын түр хороо, ажлын хэсгүүд цөөнхийн төлөөллийг оруулж би сөрөг хүчиндээ ч гэсэн хандаж хэлэхэд сөрөг хүчин ажиллахгүй байгаа учраас ард түмэн сөрөг хүчин болоод байна гэж би олон удаа давтаж хэлж байгаа шүү. Цөөнх маань эв нэгдэлтэй, учраа олоод, үндэсний эв нэгдэл, аюулгүй байдлын төлөө шударга бус зүйлтэй хамтарч тэмцэж байх ёстой шүү дээ. Парламентын Үндсэн хуулийн хяналтын хамгийн чухал хэрэгсэл бол цөөнхийн асуудал. Тэгээд энэ авлигатай тэмцэх өдөр бол Үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулж байгаа, иргэдийнхээ амьжиргаанд аюул учруулж байгаа авлигын эсрэг Улсын Их Хурал цөөнх олонхгүй бүгдээрээ хүчээ нэгтгэж

хамтарч ажиллацгаая гэж уриалж байна.

Одоо хэлэлцэх асуудалдаа орно. Хууль, тогтоолын төслийн эцэслэн батална. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Хот,суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-т “7 хоногийн Баасан гарагийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуралдааны ирц хуулийн төслийг эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно.” гэж заасны дагуу Байнгын хороо төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг бэлтгэж гишүүдэд тараасан байгаа. Эцэслэн батлуулахад бэлэн болсон байна. Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлахад Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу чуулганд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар хуулийг эцэслэн баталсанд тооцохоор заасан байгаа. Тийм учраас 39-өөс дээш гишүүн дэмжиж байж хууль эцэслэн батлагдана.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулна. Булгантуяа гишүүн суудалдаа сууя.

Газрын тосны тухай хуулийн эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Өнөөдрийн анхны санал хуралт учраас энэ санал хураалтыг бүртгэлийн санал хураалт гэж зарлаж байна. Анхны санал хураалт учраас. Бүртгэлд ороогүй гишүүд, Оюунчимэг гишүүн, Пүрэвдорж гишүүн, Туваан гишүүн, Учрал гишүүн байсан, хаашаа явсан бэ. Бүртгэлд ороогүй гишүүд, бүртгэлийн санал хураалтад оролцоогүй гишүүдийг зарлая. Бүртгэлийн санал хураалтад Ширнэнбандийн Адьшаа, Норовын Алтанхуяг, Мөнхөөгийн Оюунчимэг, Пүрэвдорж, Туваан, Учрал, Цогтгэрэл нарын гишүүд оролцоогүй байна. Бейсен гишүүн та өчигдөр дэмжээд байсан, хаачих нь вэ.

Санал хураалт явуулъя. Бэлэн үү. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Энэ хуулийг эцэслэн батлах шаардлагатай. Ард түмэн үнийн өсөлтөд бухимдаад байна шүү дээ. Үнийн өсөлтийг бууруулах шатахууны үнийн өсөлтийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулна гэж Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Хуулиа баталъя. Хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар та бүхэн харин дараа нь мөрөг хүчин хяналт тавид шаардлага тавиад хэрэгжихгүй бол дараа нь цуцалж болно шүү дээ. Ингээд санал хураалт явуулна. Төгтохоо дарга аа, Учрал гишүүн түүрүүн энд байсан. Хааччихав. Пүрэвдорж, Алтанхуяг, Ганибал 3 гишүүн дэмжчихвэл болох гээд байна. Зарим гишүүдийн орж иртэл дараагийн хуулиа баталж байя.

1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 42

гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3.Аялал, жуулчлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Горимын санал гаргаж байна. Төхөөрөмжүүд сая гацсан байна. Тийм учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. 77.4 хувийн саналаар. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

5.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

6.Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

7.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

8.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

9.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10.Концессын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Гишүүд анхааралтай байгаарай. Амарсайхан сайд аа, Баттөмөр гишүүн ээ, эсрэг гараад байна.

13.Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт

явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

14.Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

15.Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

16.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

17.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

18.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

19.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт техникийн шалтгаанаар давхацсан учир хүчингүйд тооцлоо. 19 дээр санал хураалт дахин явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Пүрэвдорж гишүүн ээ битгий хурал үймүүлээд бай. Санал хураалт явуулж байхад. Сануулж байна шүү.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

20.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

21.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

22.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

23.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Пүрэвдорж гишүүн ээ та нар сөрөг хүчний үүргээ гүйцэтгэхгүй байгаа учраас ард түмэн сөрөг хүчин болж байгаа шүү. Ажлаа хий та нар. Битгий хурал үймүүлээд бай.

24.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

25.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор

санал хураалт явуулъя. 4 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

26.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

27.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

28.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

29.Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

30.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

31.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

32.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. 48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

33. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууль. 46 гишүүн дэмжиж, тогтоол батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан:

34. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууль. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууль. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууль. Санал хураалт. Гишүүд анхааралтай. Баделхан сайд таныг би хараад л байгаа шүү. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа. Сая сайд нар гишүүд орж ирсэн байгаа учраас нэг зүйлийг тодотгож хэлье. Нямбаатар сайд аа, өнөөдөр авлигатай тэмцэх олон улсын өдөр. Авлигатай тэмцэх багц хуулийг яаралтай боловсруулж өнөөдөр ажиллаж, үдээс хойш яам дээр болон хамтарч ажиллаж ажлын хэсгийг өнөөдөр байгуулан ирэх 7 хоногт хэлэлцээж эхэлье. Энэ багц хуульд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж, Эрүүгийн хуулийн 22.1-ийг өөрчлөлт оруулж нэг л төгрөгийн хулгай хийсэн бол ялын бодлогыг чангатгаж тэр дээр

хөрөнгө хураах ялыг нэмж, нийт ард иргэд авлига хэтэрсэн учраас ингээд байна шүү дээ. Нүүрс баялгийн хулгай. Тийм учраас Хууль зүйн байнгын хороо Мөнхбаатар дарга, Нямбаатар сайд Эрүүгийн хуулийн чангатгах ялын бодлогыг ард иргэд залуучууд шаардаад байна. Энийг оруулж ирж, шийд. Ажлын хэсгүүд өнөөдөр ажиллах хэрэгтэй. Ер нь бол одоо гадаад, дотоод байдал эмзэг, эвгүй байгаа үед улс төрийн тогтвортой байдал юунаас чухал шүү. Ийм учраас дээр дооргүй бид үндэсний эв нэгдлээ эрхэмлэж, жоом, ялаагаа алах гээд гэрээ шатааж болохгүй. Парламентын ардчиллаа сөхрүүлж болохгүй. Эмзэг цаг үед байрлаж байгаа, хулгай зэлгээнтэй бүх талаараа үндэсний эрх ашгийн төлөө тангараг өргөсөн төрийн түшээд эцсээ хүртэл тэмцэнэ. Ингэхдээ парламентын ардчиллаа, Үндэсний аюулгүй байдлаа, Монгол Улсын эрх ашгийг хэзээ ч орхигдуулж ард иргэдийн дунд хагалан бутаргаж, гадаад дотоод хэсэг бүлэглэлийн нөлөөгөөр ард иргэд залуучуудын тайван жагсаалыг буруу зүйлд хөтөлж болохгүй гэж хатуу анхааруулж хэлж байна.

Ингээд хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа. Өнөөдрийн ажлуудаа энэ дээр чиглүүлж ажиллана.

Нэг юм танилцуулъя. Үдээс хойших хуралдаанаар Засгийн газраас бичиг ирүүлсэн. Дарханы арьс ширний цогцолборын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрийн асуулгын хариуг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар танилцуулахыг Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуунд үүрэг болгосон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуун 2022 оны 12 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд зүүн бүсийн аймгуудад зохион байгуулагдах Зүүн

бүсийн жижиг дунд үйлдвэрийн үйлчилгээ эрхлэгчдийн чуулга уулзалтад оролцохоор болсон тул асуулгын товгыг хойшлуулж өгнө үү гэж хүссэн. Дэгийн тухай хуулийн дагуу үдээс хойших хэлэлцэх асуудал хойшилж байна. Саяны ярьсан Эрүүгийн хууль, Авлигатай тэмцэх багц хуулиуд дээр ажлын хэсгүүд ажиллана. Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороо, түр хороод ажиллана. Хянан шалгалтын.

11.06 цаг.

Дараагийн асуудалд орно.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг танилцуулна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг.Монгол Улсын Их Хурлын Ганибалын Амартүвшинийг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Ширнэнбандийн Адьшааг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд орж байгаа. Гишүүд суугаарай. Санал хураалт. 36 гишүүн дэмжиж, 65.5 хувийн саналаар санал дэмжигдэж тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулсан. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Одоо Эдийн засгийн байнгын хороо болон бусад байнгын хороод хуралдана. Ажлын хэсгүүд хуралдана. Хяналт шалгалтын түр хороод хуралдана. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдаж, саяны энэ эрх зүйн 10 багц шинэчлэлийн асуудлыг, авлигатай тэмцэх хуулийн асуудлуудыг ярилцана.

Үдээс хойших хуралдаанаар хэлэлцэх ёстой байсан энэ Дарханы арьс ширний цогцолборын хэрэгжилтийн байдлаар талаар Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу сонсох ажиллагаа хойшлогдсоныг мэдэгдье.

11.11 цаг.

Үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ	БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ	ТЭМДЭГЛЭЛ
ДЭЛГЭРЭНГҮЙ	ШИНЖЭЭЧ
БУУЛГАЖ,	
ХЯНАСАН:	
Э.СУВД-ЭРДЭНЭ	

